




САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН
2016 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТОЙМ**



УЛААНБААТАР ХОТ
2016

Агуулга

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	3
1.1 Зах зээлийн үнэлгээ	3
1.2 Зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ)-ний дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувь, хөрвөх чадварын түвшин	4
1.3 Үнэт цаасны зах зээлийн индексүүд	5
1.4 Үнэт цаасны зах зээлийн оролцогчид	6
1.5 Үнэт цаасны зах зээлийн нийлүүлэлт	13
1.5.1 Хувьцааны арилжаа	13
1.5.2 Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны арилжаа	14
1.5.3 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа	14
1.5.4 Хөдөө аж ахуйн биржийн арилжаа	15
1.6 Үнэт цаасны зах зээлийн эрэлт талын хүчин зүйлс	15
1.6.1 Үнэт цаасны арилжааны мөнгөн гүйлгээ	16
1.6.2 Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үзүүлэлтүүд	16

ДҮРСЛЭЛ

БҮЛЭГ 1

- Дүрслэл 1. Зах зээлийн үнэлгээ
- Дүрслэл 2. ДНБ/ЗЗҮ
- Дүрслэл 3. ТОП-20 индекс
- Дүрслэл 4. Хувьцаат компанийн тоо
- Дүрслэл 5. ҮЦК-иудын тоо
- Дүрслэл 6. Хувьцааны арилжаа
- Дүрслэл 7. ҮЦТХТ-д нээгдсэн дансны тоо
- Дүрслэл 8. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь

ХҮСНЭГТ

БҮЛЭГ 1

- Хүснэгт 1. Зах зээлийн үнэлгээ өндөр 30 компани
- Хүснэгт 2. Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо
- Хүснэгт 3. Хувьцаат компанийн хувьцааны бүтэц
- Хүснэгт 4. Ногдол ашиг тараасан хувьцаат компани
- Хүснэгт 5. Зохицуулалттай этгээдийн тоо
- Хүснэгт 6. ҮЦК-иудын нийт хөрөнгө
- Хүснэгт 7. ҮЦК-иудын нийт орлого
- Хүснэгт 8. ҮЦК-иудын арилжаанд эзлэх хэмжээ
- Хүснэгт 9. ҮЦК-иудын харилцагчдын тоо
- Хүснэгт 10. Үнэт цаасны арилжааны үзүүлэлт
- Хүснэгт 11. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
- Хүснэгт 12. ХААБ-ийн арилжааны үнийн дүн, хэмжээ

ШИГТГЭЭ

БҮЛЭГ 1

- Шигтгээ 1. Зах зээлийн үнэлгээ, ТОП-20 индексийн өсөлтийн шалтгаан
- Шигтгээ 2. ҮЦК-иудыг олон улсын стандартад нийцүүлэн чадавхжуулах шаардлага

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Үнэт цаасны зах зээлийн 2016 оны 4 дүгээр улирлын тоймоор салбарын хөгжлийг илэрхийлэгч үзүүлэлтүүд болох зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, хувьцааны индекс, бүртгэлтэй компанийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзлээ. Түүнчлэн үнэт цаасны зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг илэрхийлэгч үзүүлэлтүүд болон дэд бүтцийн төлбөр тооцоо, хадгаламжийн үзүүлэлтүүд, үнэт цаасны арилжааны дүн, зохицуулалттай этгээд болон хөрөнгө оруулагчдын үнэт цаасны арилжаанд эзлэх оролцоог хураангуй байдлаар харуулав.


НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас үнэт цаасны зах зээлийн хөгжлийг үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, үнэт цаасны арилжааны ДНБ-д эзлэх хувь, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хувьцааны индекс гэсэн үндсэн үзүүлэлтүүдээр илэрхийлж авч үздэг бөгөөд тухайн улсын хувьд дээрх хөгжлийн үзүүлэлтүүд ямар түвшинд хүрснээс хамаарч гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгдэх, хөрөнгө оруулалтын урсгал бий болох, улмаар бүс нутгийн хэмжээнд өрсөлдөхүйц түвшинд байгаа эсэхийг тодорхойлдог.

1.1 Зах зээлийн үнэлгээ

Үнэт цаасны зах зээлийн багтаамж, түүний эдийн засгийн өсөлтийг дунд болон урт хугацаанд дэмжигч гол үзүүлэлт нь үнэт цаасны зах зээлийн үнэлгээ бөгөөд энэхүү үзүүлэлтийн өсөлт, бууралт нь үнэт цаасны зах зээлийн хөгжлийн түвшинг, улмаар эдийн засгийн хөгжилд хэрхэн нөлөө үзүүлж байгааг илэрхийлэгч үндсэн индикатор болдог.

Дүрслэл 1. Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2016 оны 4 дүгээр улирлын байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 1,474.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 211.7 тэрбум төгрөг буюу 16.8 хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлтөд ТОП-20 индексэд багтдаг “Таван толгой” ХК, “Монгол Шуудан” ХК, “Говь” ХК, “Адуун чулуун” ХК-ийн хувьцааны ханш 9.36, 60.2, 19.4, 49.4 хувиар тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн. Харин ТОП-20 индексэд багтдаг “АПУ” ХК, “Сүү” ХК, “Багануур” ХК, “Шивээ овоо” ХК -ийн хувьцааны ханш 10.7, 21.3, 19.0, 18.0 хувиар тус тус буурсан байна.

Олон улсын зах зээл дээр түүхий эдийн үнэ ханш сэргэх төлөв ажиглагдаж байгаа нь уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын экспортын орлого нэмэгдэх зэргээр үйл

ажиллагаанд эерэг нөлөө үзүүлсэн нь “Таван толгой” ХК, “Адуун чулуун” ХК зэрэг компаниудын хувьцааны ханш өсөхөд нөлөөлсөн байна.

Тайлант хугацаанд нийт зах зээлийн үнэлгээний 89.6 хувийг 30 компани бүрдүүлсэн бөгөөд эдгээр компаниудын ихэнх нь уул уурхай, аж үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нь уул уурхайн салбарын өсөлт, бууралттай холбоотойгоор дотоодын үнэт цаасны зах зээлийн үнэлгээнд шууд нөлөө үзүүлж байна. Үүнд:

Хүснэгт 1. Зах зээлийн үнэлгээ өндөр 30 компани

№	Үнэт цаасны нэр	Үнэлгээ /тэрбум төгрөг/	№	Үнэт цаасны нэр	Үнэлгээ /тэрбум төгрөг/
1	АПУ	294.3	16	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	20.1
2	МИК ХОЛДИНГ	252.6	17	ТАЛХ ЧИХЭР	18.6
3	ТАВАН ТОЛГОЙ	142.7	18	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	17.7
4	ГОВЬ	79.2	19	БЭРХ УУЛ	15.3
5	БАГАНУУР	61.7	20	ГЕРМЕС ЦЕНТР	13.3
6	СҮҮ	44.08	21	МАТЕРИАЛИМПЕКС	12.3
7	ШИВЭЭ ОВОО	38.5	22	АТАР-ӨРГӨӨ	11.3
8	МОНГОЛ ШУУДАН ХК	33.8	23	МАХ ИМПЕКС	10.4
9	ШАРЫН ГОЛ	27.9	24	ХАЙ БИ ОЙЛ	10.3
10	МОНГОЛ СЕКЮРИТИЕС	26.7	25	СИЛИКАТ	9.5
11	ТАХЬ-КО	25.7	26	ТЕХНИК ИМПОРТ	8.8
12	БИ ДИ СЕК	25.6	27	АРИГ ГАЛ	8.0
13	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	22.6	28	ЖЕНКО ТУР БЮРО	6.8
14	ДАРХАН НЭХИЙ	21.5	29	ХӨХ ГАН	6.7
15	ГУТАЛ	20.4	30	МОНГОЛ ШИЛТГЭЭН	6.4

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


1.2 Зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ)-ний дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувь, хөрвөх чадварын түвшин

2016 оны жилийн эцсийн байдлаарх ЗЗҮ-г үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэрлэсэн ДНБ-ны хэмжээтэй харьцуулахад 6.2 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.8 хувиар өсчээ. Харин тайлант хугацааны зах зээлийн үнэлгээнд хувьцааны арилжааны үнийн дүнг харьцуулан хөрвөх чадварыг тооцсон дүн 3.32 нэгж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.91 хувиар өссөн байна.

Хөрвөх чадварын түвшин өсөхөд “Монгол шуудан” ХК-ийн 33.9 сая ширхэг хувьцааг 6.3 тэрбум төгрөгөөр хувьцааны анхдагч зах зээлд арилжсан болон багцын арилжаагаар нэр бүхий 11 компанийн 41.9 сая ширхэг хувьцааг 34.1 тэрбум төгрөгөөр арилжсан нь голлох нөлөөг тус тус үзүүлсэн бөгөөд багцын арилжаа нь нийт хувьцааны арилжааны 69.6 хувийг бүрдүүлсэн.

Манай улсын хувьд хувьцааны хөрвөх чадварын түвшин бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад доогуур түвшинд байгаа ба үүнд хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьцаа хэт төвлөрсөн, компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдал хангалтгүй, хангалттай хэмжээний шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ байхгүй, олон нийтийн хөрөнгө оруулалт, хувьцааны талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг зэрэг хүчин зүйлс гол нөлөөг үзүүлж байна.

Дүрслэл 2. ДНБ/ЗЗҮ




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

1.3 Үнэт цаасны зах зээлийн индексүүд

Тайлант хугацаанд ТОП-20 индекс өмнөх оны үетэй харьцуулахад 3.4 хувиар буурч, 12,456.06 нэгжид хүрсэн бөгөөд индексийн дээд үзүүлэлт 12,939.50, доод үзүүлэлт 10,485.71, дундаж үзүүлэлт 11,550.09 нэгж байна.

MSE ALL индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.9 хувиар буурч, 861.24 нэгжид хүрчээ. Тус индексийн дээд үзүүлэлт 894.94 нэгж, доод үзүүлэлт 761.16 нэгж, дундаж үзүүлэлт 827.17 нэгжтэй гарлаа.

Дүрслэл 3. ТОП-20 индекс



Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

Шигтгээ 1: Зах зээлийн үнэлгээ, ТОП-20 индексийн динамик үзүүлэлтээс харахад 2007, 2011 онуудад огцом өсөлт ажиглагдсан бөгөөд 2007-2008 оны хооронд нийт 8 компани үнэт цаасаа олон нийтэд санал болгон арилжаалсан нь арилжааны хэмжээ, зах зээлийн үнэлгээг огцом өсгөхөд нөлөө үзүүлжээ.


Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2011 онд уул уурхайн салбарын өсөлттэй холбоотойгоор 17.5 хувьд хүрч, бүс нутаг болоод олон улсын хэмжээнд эдийн засгийн өсөлтийн хурдаар тэргүүлэх болсон бөгөөд үүнтэй холбоотойгоор Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй, ТОП-20 индексийг бүрдүүлэгч уул уурхайн салбарын компаниудын хувьцааны хани

огцом нэмэгдэх болсон. Үүнийг дагаад манай улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид болон мэргэжлийн зуучлагч брокеруудын тоо ихээр нэмэгдсэн байна. Гэвч 2012 оноос хойших хугацаанд олон улсын санхүүгийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ ханш унасан, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан, эдийн засгийн өсөлт удааширсан зэрэг шалтгаануудын улмаас манай хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадварын үзүүлэлтүүд буурсаар байна.

Хэдийгээр хөрөнгийн зах зээлийн хөгжлийн суурь нөхцөл болох үнэт цаасны зах зээлийн хууль, эрх зүйн орчин сүүлийн жилүүдэд сайжирч, хяналт, зохицуулалтын оновчтой тогтолцоо бүрдэх боломж бий болж байгаа хэдий ч, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн хөгжил сул, тэр дундаа төлбөр, тооцоо, арилжааны систем болон мэргэжлийн зуучлагч байгууллагуудын хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй, хангалттай хэмжээний шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлт хомс, үнэт цаасны арилжаа, хөрвөх чадвар доогуур, үр ашигтай хяналт, зохицуулалтын механизм бүрдээгүй зэрэг нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд сөрөг нөлөөг үзүүлж байна.

1.4 Үнэт цаасны зах зээлийн оролцогчид

Тайлант хугацаанд Хорооны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд нийт 302 компани бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байна.



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2016 онд “Ай Түүлс” ХХК нь үнэт цаасаа олон нийтэд анх удаа санал болгон гаргасан хэдий ч тогтоосон хугацаанд олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлж чадаагүй тул Хорооны 2016 оны 267 дугаар тогтоолоор уг компанийн үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлээс хассан болно.

Хүснэгт 2. Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо

Үнэт цаас гаргагчийн өмчийн бүтэц	СЗХ	“Монголын хөрөнгийн бирж” ХК	“ҮЦТТТХТ” ХХК
Төрийн өмчит	32	21	22
Төрийн өмчийн оролцоотой	10	16	15
Орон нутгийн оролцоотой	15	-	8
Хувийн өмчит	245	199	276
Нийт	302	236	321

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2013-2016 оны хооронд Хорооны зүгээс хөрөнгийн биржийн нэр хүндийг өсгөх, үнэт цаасны бүртгэлийн ангиллыг шинэчлэх, Хорооны бүртгэлийг бүртгэлийн /listing/ хэлбэрээс

зөвшөөрлийн /registering/ хэлбэрт шилжүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах хүрээнд өмч хөрөнгө нь үрэгдсэн, хувьцаа эзэмшигчдийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ сүүлийн 3-аас дээш жилийн хугацаанд тогтмол биелүүлээгүй компаниудын үнэт цаасыг бүртгэлээс хасах, хууль хяналтын байгууллагуудад шилжүүлэх хийгээд компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зэрэг тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 3. Хувьцаат компанийн хувьцааны бүтэц

Үнэт цаас гаргагчийн ангилал	2014 он	2015 он	2016-П
Төрийн мэдлийн бус хувьцаа	2,913,776	2,809,930	2,472,245
Төрийн мэдлийн хувьцаа	2,254,152	2,246,316	4,520,560
Орон нутгийн оролцоотой	29,046	29,046	29,046
Нийт	5,196,974	5,085,292	7,021,850
Эрдэнэс Тавантолгой /Иргэн/	967,134	2,558,176	2,212,224
Эрдэнэс Тавантолгой /ААН/	4,915	5,139	5,203
Эрдэнэс Тавантолгой /Төр/	14,027,951	12,436,685	12,782,573
Нийт	15,000,000	15,000,000	15,000,000
Хаалттай ХК	-	172,753	174,958
Нийт	-	172,753	174,958

Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

Түүнчлэн Ашигт малтмалын тухай хуулийн 5.6-д заасны дагуу 15 стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хуулийн этгээдийн хувьцааны 10 хувийг хөрөнгийн биржээр арилжаалах хуулийн шаардлагыг хэрэгжүүлэх нь үнэт цаасны зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой бөгөөд дээрх ордын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа нийт 24 хуулийн этгээд байгаагаас 4 /”Багануур” ХК, “Шивээ овоо” ХК, “Таван толгой” ХК, “Дархан төмөрлөгчийн үйлдвэр” ХК/ нь хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.

Хувьцаат компанийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт: Тайлант хугацаанд “ҮЦТТТХТ” ХХК нийт 10 ХК-тай ногдол ашгийн гэрээ байгуулж 8,294 харилцагчийн дансанд 5.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийг байршуулсан байгааг хүснэгтээр үзүүлбэл.

Хүснэгт 4. Ногдол ашиг тараасан хувьцаат компани

№	ХК-ийн нэр	Нийт ҮЦ-ын тоо ширхэг	Нэгж хувьцаанд тараасан	ХЭ-ийн тоо	ҮЦ-ны тоо ширхэг	Мөнгөн дүн
1	“Адуунчулуун” ХК	3,151,304	90.0	1,176	392,534	35,328,060.00
2	“Тахь-Ко” ХК	1,189,983	97.2	624	1,189,983	115,666,347.60
3	“МИК холдинг” ХК	20,709,320	217.08	104	20,709,320	4,505,739,518.52
4	“Атар-Өргөө” ХК	174,136	270.0	351	13,848	3,738,960.00
5	“АПУ” ХК	74,287,700	63.0	3,075	5,360,899	337,736,637.00
6	“Могойн гол” ХК	829,622	4.5	952	406,515	1,829,317.50
7	“Гермес центр” ХК	78,543,001	4.0	927	11,196,884	44,787,536.00
8	“Ган хийц” ХК	242,464	90.0	100	13,682	1,231,380.00
9	“Баянтээг” ХК	252,608	90.0	247	16,331	1,469,790.00
10	“Баянгол зочид буудал” ХК	423,065	319.5	738	59,771	19,096,834.50
	Нийт			8,294	39,359,767	5,066,624,381.12

Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид: Тайлант хугацаанд 62 ҮЦК Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас үнэт цаасны арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх 1, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх 3, хөрөнгө оруулалтын менежментийн 15 компани үйл ажиллагаа явуулж байгаа бол хөдөө аж ахуйн биржийн арилжаа, зуучлалын чиглэлээр арилжаа эрхлэх 1, бараа, түүхий эдийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх 37 этгээд тусгай зөвшөөрөлтэй байна. Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай этгээдүүдийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 5. Зохицуулалттай этгээдийн тоо

№	Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч	Оролцогчдын тоо
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх	2
2	Үнэт цаасны төлбөр тооцооны	1
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн	1
4	Хөрөнгө оруулалтын менежментийн	13
5	Брокер, дилер	62
6	Кастодиан банк	3
7	Андеррайтер /давхардсан тоогоор/	25
8	Хөрөнгө оруулалтын зөвлөх /давхардсан тоогоор/	15
Нийт		81
9	Хөдөө аж ахуйн түүхий эдийн арилжаа эрхлэх	1
10	Хөдөө аж ахуйн түүхий эдийн брокер	37
11	Аудитын компани	44
12	Үнэлгээний компани	20
13	Хуулийн компани	19

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 компанид олгосон бол Засгийн газрын 2015 оны 147-р тогтоол, Сангийн сайдын 2015 оны 280 дугаар тушаалын дагуу 2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс “ҮЦТТХТ” ХХК-ийг үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх чиг үүрэг бүхий бие даасан 2 хуулийн этгээд болгон өөрчлөн зохион байгуулах чиглэлээр Сангийн яамтай хамтран ажиллав.

Хорооны 2015 оны 312 дугаар тогтоолоор “Дилерийн арилжааны төв” ХХК-д үнэт цаасны арилжаа эрхлэх, үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд ингэснээр үнэт цаасны зах зээлд 2 дахь бирж байгуулагдан үйл ажиллагаа явуулах боломж бүрдээд байна. Үнэт цаасны зах зээлд арилжаа эрхлэх байгууллагууд үүсэн бий болох нь зах зээл дээрх төгс шударга өрсөлдөөнийг бий болгох, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, үйлчилгээний /transaction cost/-г бууруулах, жижиг, дунд аж ахуйн нэгжүүд хямд зардлаар санхүүжилт татах боломжууд бий болох боломж бүрдээд байна.

Мэргэжлийн зуучлагч ҮЦК /брокер, дилер, андеррайтер/-дын өнөөгийн нөхцөл байдал:

Манай улсын хувьд 2016 оны жилийн эцсийн байдлаар нийт ҮЦК-иудын тоо 62 байгаа нь хөрөнгө оруулагчдын хувьд хангалттай хэмжээнд хүрсэн хэдий ч, санхүүгийн хувьд чадавхтай, үнэт цаасны арилжаанд идэвхтэй оролцдог, холбогдох хууль тогтоомж болон Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилладаг компаниуд

цөөн байгаа тул хөрөнгийн зах зээлийн хөгжлийг цаашид нэмэгдүүлэх, мэргэжлийн оролцогч байгууллагуудыг чадавхжуулах замаар үнэт цаасны арилжааны хэмжээ, хөрвөх чадвар болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай тулгарч байна.

Хүснэгт 6. Нийт хөрөнгө /төгрөгөөр/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2015 он	2016 он	Өсөлт/бууралт
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	47,543,265,612.05	71,594,287,709.44	50.6%
2	Эргэлтийн бус хөрөнгө	20,410,824,681.02	19,684,476,026.75	-3.6%
3	Нийт актив	67,954,090,293.07	91,278,763,736.18	34.3%
4	Өр төлбөр	6,369,641,323.57	24,483,336,440.91	284.4%
5	Эздийн өмч	61,584,448,969.50	66,795,427,295.27	8.5%
6	Нийт пассив	67,954,090,293.07	91,278,763,736.18	34.3%

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

2016 оны жилийн эцсийн байдлаар нийт 62 брокер, дилерийн компаниас нэр бүхий 21 ҮЦК нь ашигтай, 35 ҮЦК нь алдагдалтай, 6 ҮЦК нь ашиг, алдагдалгүй ажилласан байна. Тайлант хугацаанд алдагдалтай ажилласан 35 ҮЦК-иас 14 ҮЦК хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжаанд оролцоогүй, 16 ҮЦК хөрөнгийн биржийн гишүүн компанид тавигддаг гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлээгүй байгаа нь цаашид ҮЦК-иудын санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх, хөрөнгөжүүлэх, эдгээр компаниудыг хооронд нь нэгтгэх, нийлүүлэхийг бодлогоор дэмжиж, үйл ажиллагааны хувьд бие даасан, мэргэшсэн боловсон хүчинтэй, техник програм хангамжийн хувьд олон улсын түвшинд нийцсэн мэргэжлийн зуучлагчийн түвшинд хүргэх шаардлагатай тулгарч байна.

Хүснэгт 7. Нийт орлого /төгрөгөөр/

№	Орлогын хураангуй тайлан	2015 он	2016 он
1	Үйл ажиллагааны орлого	3,639,407,392.52	5,492,161,108.93
2	Ногдол ашгийн орлого	40,805,708.98	493,082,272.23
3	Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал	6,368,915,342.62	6,097,590,807.26
4	Ажиллагчдын цалингийн зардал	2,682,481,411.28	2,778,276,766.47
5	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	1,013,114,613.93	847,699,782.78
6	Санхүүгийн зардал	108,839,490.59	588,053,464.77
7	Бусад зардал	354,831,031.95	82,365,109.68
8	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-106,575,808.85	641,352,361.25
9	Бусад ашиг (алдагдал)	-103,122,642.83	-384,053,432.11
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-604,182,963.06	1,134,575,339.65
11	Орлогын татварын зардал	133,607,653.44	117,962,661.01
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-737,790,616.50	1,016,612,678.64

Эх үүсвэр: Санхүүгийн зохицуулах хороо

2016 онд Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийт 416.9 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн. Үүнээс нэр бүхий 10 ҮЦК нийт 404.0 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийсэн бөгөөд энэ нь нийт арилжааны 96.9 хувийг бүрдүүлж байгаа бол үлдсэн 3.09 хувийг бусад ҮЦК бүрдүүлсэн. Дээр дурдсан 10 ҮЦК-иас арилжааны дүнгээрээ тэргүүлсэн нэр бүхий 5 ҮЦК нийт арилжааны 80.0 хувийг бүрдүүлсэн байгаа нь хөрөнгийн биржийн нийт гишүүн 58 ҮЦК-ийн 8.6 хувь, арилжаанд оролцох эрхтэй 42 ҮЦК-ийн 11.9 хувь нь тус тус болж байна.

Хүснэгт 8. ҮЦК-иудын арилжаанд эзлэх хэмжээ /тэрбум төгрөг/


№	Компанийн нэрс	Үнэт цаасны арилжааны хэмжээ /тэрбум төгрөг/	Арилжаанд эзлэх хувь
---	----------------	--	----------------------

1	"Би Ди Сек ҮЦК" ХК	136.2	32.7%
2	"Новел инвестмент ҮЦК" ХХК	66.9	16.0%
3	"Ти Ди Би капитал ҮЦК" ХХК	63.0	15.1%
4	"Тэнгэр капитал ҮЦК" ХХК	46.3	11.1%
5	"Ард секьюритиз ҮЦК" ХХК	21.1	5.1%
	Нийт	333.5	80.0%
6	"Монсек ҮЦК" ХХК	18.9	4.5%
7	"Дэү Секьюритис Монгол ҮЦК" ХХК	16.3	3.9%
8	"Голомт секьюритиз ҮЦК" ХХК	12.0	2.9%
9	"Гаули ҮЦК" ХХК	11.8	2.8%
10	"Стандарт инвестмент ҮЦК" ХХК	11.5	2.8%
	Нийт	404.0	96.9%
	Бусад	12.9	3.1%

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

Үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтерийн компаниудын тоо /давхардсан тоогоор/ 2010-2012 оны хооронд 95 болж, огцом өссөн. Дээрх өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн нь төрөөс “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааг Монгол Улсын иргэн бүрт үнэ төлбөргүй эзэмшүүлэх шийдвэр гаргасан нь үнэт цаасны зах зээлд мэргэжлийн зуучлагчид болох брокер, дилерийн компаниудын тоо огцом өсөхөд хүргэсэн.

Дүрслэл 5. ҮЦК-иудын тоо /брокер, дилер/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хэдийгээр үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн компанийн тоо нэмэгдсэн ч, мэргэжлийн өндөр түвшинд үйл ажиллагаа явуулах мэргэжлийн зуучлагчдын тоо нэмэгдэх бус харин эсрэгээр үнэт цаасны арилжаанд оролцдоггүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаггүй, холбогдох хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүрэг, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангадаггүй компаниудын тоо нэмэгдсэн бөгөөд үүнийг дагаад хувьцааны үнэ ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах, зах зээлд худал мэдээлэл тараах зэрэг үйл ажиллагааг зарим нэр бүхий компаниуд гаргах болсон нь манай улсын хөрөнгийн зах зээлд итгэх хөрөнгө оруулагчдын оролцоо, идэвх буурахад нөлөөлсөн.

Үүнтэй холбоотойгоор Хорооны зүгээс 2013-2015 оны хооронд мэргэжлийн зуучлагч байгууллагуудын үйл ажиллагаа, санхүү, өөрийн хөрөнгө, хүний нөөцийн байдалд тавих газар дээрх болон зайны хяналт, шалгалтыг эрчимжүүлэн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага хангаагүй компаниудын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж ирсэн.

2016 оны жилийн эцсийн байдлаар, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д үнэт цаасны данс эзэмшигчээр бүртгэлтэй нийт харилцагчдын тоог ҮЦК тус бүрээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 9. ҮЦК-иудын харилцагчдын тоо

№	Компанийн нэрс	Харилцагчийн төрөл				Нийт харицлагчдын тоо	Эзлэх хувь
		Иргэн		Аж ахуйн нэгж байгууллага			
		Монгол	Гадаад	Монгол	Гадаад		
1	“Би Ди Сек ҮЦК” ХК	101014	728	425	92	102259	15
2	“Аргай бэст ҮЦК” ХХК	38420	3	130	1	38554	6
3	“Зэргэд ҮЦК” ХХК	35677	1	57	0	35735	5
4	“Монсек ҮЦК” ХХК	33675	16	63	0	33754	5
5	“Алтан хоромсог ҮЦК” ХХК	31342	3	25	0	31370	5
6	“Мэргэн санаа ҮЦК” ХХК	30304	1	26	0	30331	4
7	“Стандарт Инвестмент ҮЦК” ХХК	27852	68	37	4	27961	4
8	“Таван богд ҮЦК” ХХК	27308	109	57	0	27474	4
9	“Дархан брокер ҮЦК” ХХК	27023	1	25	0	27049	4
10	“Өндөрхаан инвест ҮЦК” ХХК	26340	0	23	0	26363	4
11	“Эм Даблю Ти Эс ҮЦК” ХХК	25870	3	145	0	26018	4
12	“Гүүдсек ҮЦК” ХХК	25764	2	32	0	25798	4
13	“Бумбат Алтай ҮЦК” ХХК	25575	5	18	0	25598	4
14	“Дэлгэрхангай секьюритиз ҮЦК” ХХК	25510	8	63	2	25583	4
15	“Масдак ҮЦК” ХХК	25220	3	23	0	25246	4
16	“Тулгат чандмань баян ҮЦК” ХХК	20083	4	25	0	20112	3
17	“Санар ҮЦК” ХХК	18206	2	21	0	18229	3
18	“Булган брокер ҮЦК” ХХК	16277	1	63	3	16344	2
19	“Азиа пасифик секьюритис ҮЦК” ХХК	14076	137	20	13	14246	2
20	“Блюскай секьюритиес ҮЦК” ХК	13054	1	1	0	13056	2
21	“Ард секьюритиз ҮЦК” ХХК	10714	25	58	2	10799	2
	Нийт	599304	1121	1337	117	601879	89
22	Бусад 41 ҮЦК	72052	575	764	42	73833	11

Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

Шигтгээ 2: 2008 оны дэлхийн санхүүгийн хямрал болон сүүлийн жилүүдэд үүсч буй санхүү, эдийн засгийн таагүй нөхцөл байдалтай холбоотойгоор олон улсын санхүүгийн зохицуулагчид мэргэжлийн зуучлагч байгууллагуудын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх, эрсдэл даах түвшинг өсгөх арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн ба мэргэжлийн зуучлагчид нь харилцагч, хөрөнгө оруулагчдын хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусад нь хадгалах, зүй бусаар ашиглах явдлаас урьдчилан сэргийлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах санг байгуулах зэрэг тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Манай улс хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн хөгжлөөр ижил түвшний бусад орнуудтай харьцуулахад хангалтгүй, тэр дундаа төлбөр, тооцоо, арилжааны систем болон мэргэжлийн зуучлагч байгууллагуудын хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй, хангалттай хэмжээний шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлт хомс, үнэт цаасны арилжаа, хөрвөх чадварын түвшин доогуур байгаа нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд сөрөг нөлөөг үзүүлж байна.

Хорооны зүгээс Дэлхийн банкны Олон салбарыг хамарсан техник туслалцааны хоёр дахь шатны төслийн хүрээнд санхүү, хүний нөөц, техник програм хангамжийн хувьд чадавхтай мэргэжлийн зуучлагч компаниудыг бий болгох замаар төлбөрийн баталгааны санг байгуулах, өөрийн орны онцлогтой нийцүүлэн төлбөр, тооцоонд DVP /төлбөрийн эсрэг нийлүүлэлт/ загварыг бүрэн нэвтрүүлэх, арилжааны дараах төлбөр тооцооны горимыг T+2 эсхүл T+3-д зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан шилжүүлэх, урт хугацаанд тооцооны байгууллага байгуулагдах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлж, улмаар гадаадын хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх болон хөрөнгийн зах зээлд итгэх итгэлийг сэргээх бодлогын чиглэлийг баримталж ажиллаж байна.

Энэ ажлын хүрээнд Хорооны зүгээс үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн хөгжлийг хөгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн хөгжлийг сайжруулах хүрээнд төлбөр, тооцоонд DVP загварыг бүрэн нэвтрүүлж, ашиглах, мэргэшсэн, санхүүгийн нөөц боломжтой мэргэжлийн зуучлагчдыг нэмэгдүүлэх замаар төлбөрийн баталгааны санг байгуулах, урт хугацаанд тооцооны байгууллага /ССР/ байгуулагдах нөхцөлийг бүрдүүлэх;*
- 2. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах, үнэт цаасны арилжаа, хөрвөх чадварын түвшинг нэмэгдүүлэхийн тулд төлбөр, тооцооны горимыг T+2, T+3 горимд шилжүүлэх замаар гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцох боломжийг нэмэгдүүлэх;*
- 3. Мэргэжлийн зуучлагчдыг чадавхжуулж, санхүү, хүний нөөцийн хувьд сайжруулах, үндсэн дээр барьцаа хөрөнгө байршуулах санхүүгийн чадавхтай болгох зэрэг арга хэмжээг авсны үндсэн дээр маржин арилжаа хийх, улмаар үнэт цаас зээлдүүлэх тогтолцоо, үүсмэл санхүүгийн зах зээл хөгжих боломжийг нэмэгдүүлэх;*
- 4. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах сан байгуулах замаар хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалах эрх зүйн орчинг сайжруулах;*
- 5. Мэргэжлийн зуучлагчдын үйл ажиллагаанд олон улсын түвшинд нийцсэн “back office”-ын програм хангамжийг нэвтрүүлж, арилжаа, төлбөр, тооцооны үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, улмаар санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээлд оролцох оролцоог нэмэгдүүлэх;*
- 6. Хувийн компаниуд дотоодын зах зээл дээр олон нийтэд үнэт цаасаа санал болгон гаргах /IPO/ замаар амжилттай санхүүжилт татаж чадах эсэх нь андеррайтерийн компаниудын үүрэг, оролцооноос шууд хамааралтай байдаг тул андеррайтерийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлж, санхүүгийн хувьд чадавхтай болгох, тэдгээрийн үүрэг, хариуцлагыг өсгөх замаар хөрөнгийн зах зээлд чанартай сайн бүтээгдэхүүн, амжилттай IPO-ын тоог нэмэгдүүлэх.*

Цаашид үнэт цаасны зах зээл дээр мэргэшсэн боловсон хүчинтэй, санхүүгийн чадавхтай, холбогдох хууль тогтоомж болон Хорооноос тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангаж ажилладаг үнэт цаасны компаниуд бий болсноор төлбөрийн баталгааны сан байгуулагдах нөхцөлийг бүрдүүлж, дэд бүтцийн хөгжил болоод үнэт цаасны зах зээлийн арилжаа, хөрвөх чадварын түвшин нэмэгдэх, төлбөр, тооцооны горим олон улсын стандартад нийцсэн T+2, эсхүл T+3-д шилжих боломж бүрдэнэ.

1.5 Үнэт цаасны зах зээлийн нийлүүлэлт

2016 онд “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан нийт 348.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36.1 хувиар буурчээ. Нийт арилжааны 14.1 хувийг хувьцаа, 85.9 хувийг ЗГҮЦ-ны арилжаа тус тус эзэлсэн байна.

Хүснэгт 10. Үнэт цаасны арилжааны үзүүлэлт


Үнэт цаасны төрөл		Хийгдсэн арилжааны тоо	Арилжагдсан тоо хэмжээ /сая ширхэг/	Арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг/
Хувьцаа	Анхдагч зах зээл	1	33.9	6.3
	Хоёрдогч зах зээл	244	59.8	42.7
ЗГҮЦ	Анхдагч зах зээл	31	3.1	280.5
	Хоёрдогч зах зээл	77	0.196	19.2

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

1.5.1 Хувьцааны арилжаа

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 244 удаагийн арилжаагаар 126 компанийн 93.7 сая ширхэг хувьцааг 49.0 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна. Хувьцааны арилжааны 69.6 хувь буюу 34.1 тэрбум төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, үлдэх 30.4 хувь буюу 14.9 тэрбум төгрөгийн гүйлгээг энгийн арилжаа тус тус бүрдүүлсэн.

Дүрслэл 6. Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд багцын арилжаагаар нийт 11 компанийн 41.9 сая ширхэг хувьцааг 34.1 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 69.6 хувийг эзэлсэн бол тендер саналын арилжаагаар “Түшиг уул” ХК-ийн 17.0 мянган ширхэг хувьцааг 8.4 сая төгрөгөөр, “Газар сүлжмэл” ХК-ийн 2.1 мянган ширхэг хувьцааг 88.6 сая төгрөгөөр тус тус арилжсан байна.

Хорооны зүгээс үнэт цаасны зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, өөрийгөө зохицуулах байгууллагын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор үнэт цаасны бүртгэлийн журамд зохицуулалтын өөрчлөлт хийснээр Хороо болон хөрөнгийн биржийн чиг үүргийн давхардлыг бууруулж, компаниуд хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлж, урт хугацааны санхүүжилтийг татах орчныг улам хялбаршуулсан алхам болоод байна.

1.5.2 Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны арилжаа

2014 оны 11 дүгээр сараас “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаас арилжаалагдаж эхэлснээс хойш нийт 826.9 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 8.8 сая ширхэг үнэт цаас анхдагч зах зээл дээр арилжаалагдсан байна.

ЗГҮЦ нь Монголбанк болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан арилжаалагдаж байгаа бөгөөд 2015 оны байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан нийт 510.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 5.4 сая ширхэг ЗГҮЦ-ыг анхдагч зах зээлийн арилжаагаар арилжсан бол хоёрдогч зах зээлийн арилжаагаар 52.3 мянган ширхэг үнэт цаас 5.1 тэрбум төгрөгөөр тус тус арилжигдсан байна.

Анхдагч зах зээлийн арилжаа:

2016 онд нийт 31 удаагийн ЗГҮЦ-ны арилжаагаар 3.1 сая ширхэг үнэт цаасыг 280.5 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Тайлант хугацаанд анхдагч зах зээл дээр нийт 280.5 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжаалагдсанаас 12 долоо хоногтой үнэт цаас нийт арилжааны 30.3%-ийг, 28 долоо хоногтой үнэт цаас 31.7%, 39 долоо хоногтой үнэт цаас 22.9%, 52 долоо хоногтой үнэт цаас 13.3%-ийг, 2 болон 3 жилийн урт хугацаатай үнэт цаас 1.8%-ийг тус тус эзэлж байна.

Хоёрдогч зах зээлийн арилжаа:

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааг 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр нээсэн бөгөөд тайлант хугацаанд нийт 196.4 мянган ширхэг үнэт цаас 19.2 тэрбум төгрөгөөр арилжигдсан. ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаанд “Новел инвестмент”, “Дэү секьюритиз”, “Голомт секьюритиз”, “БиДиСек”, “Стандарт инвестмент”, “Ард капитал групп” зэрэг ҮЦК-иуд идэвхтэй оролцсон байна

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан арилжаалагдсан ЗГҮЦ-ны хэмжээ буурсан нь биржийн нийт үнэт цаасны арилжааны үнийн дүн буурахад голлох нөлөө үзүүлжээ. Мөн макро эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал муудсантай холбоотойгоор Засгийн газрын зүгээс төсвийн алдагдлыг үнэт цаас гарган нөхөх бодлогын арга хэмжээг өөрчилсөн, мөн дотоодын зах зээлээс үнэт цаас гарган санхүүжилт татахад хүндрэлтэй байгаа нь ЗГҮЦ-ны нийлүүлэлтийг арилжааны идэвх бууруулахад тус тус нөлөөлсөн байна.

1.5.3 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

Тайлант хугацаанд Хорооны 2016 оны 305 дугаар тогтоолоор “МИК Актив арав” ХХК-ийн 1,030,173 ширхэг, 307 дугаар тогтоолоор “МИК Актив арван нэг” ХХК-ийн 709,007 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг тус тус бүртгээд байна.

Хүснэгт 11. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /тэрбум төгрөг/

ХБҮЦ гаргагч	Нийт гаргасан үнэт цаас	"ҮЦТГТХТ" ХХК-д бүртгэгдсэн	Зээлдэгчийн тоо
“МИК активнэг ТЗК” ХХК	328.1	322.9	6,658
“МИК активхоёр ТЗК” ХХК	224.8	222.1	5,290
“МИК активгурав ТЗК” ХХК	328.5	324.6	6,593
“МИК активдөрөв ТЗК” ХХК	459.4	452.3	9,510
“МИК активтав ТЗК” ХХК	301.2	294.3	5,805
“МИК активзургаа ТЗК” ХХК	267.8	261.7	5,188
“МИК активдолоо ТЗК” ХХК	299.6	293.8	5,414

“МИК актив найм ТЗК” ХХК	189.8	186.3	3,291
“МИК актив ес ТЗК” ХХК	137.5	137.2	1,719
“МИК актив арав ТЗК” ХХК	103.0	-	1,585
“МИК актив арван нэг ТЗК” ХХК	70.9	-	1,135
Нийт	2,710.6	2,495	52,188

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

“МИК ОССК” ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах хүрээнд тусгай зориулалтын компаниудыг үүсгэн байгуулж, Хорооноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, хөрөнгө итгэмжлэн удирдах зөвшөөрөл авсан бөгөөд 2015 онд “МИК ОССК” ХХК нь олон нийтэд 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 20,709,320 ширхэг үнэт цаасыг санал болгож, нээлттэй ХК болсон. ХБҮЦ-ны 90 хувийг Монголбанк, үлдсэн 10 хувийг ипотекийн зээлийн багц хөрөнгөө худалдсан банкууд эзэмшиж байна.

1.5.4 Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

Тайлант хугацаанд ХААБ ХХК-аар дамжин 181 удаагийн арилжаа явагдаж, нийт 463 тэрбум төгрөгийн бараа, түүхий эд арилжаалагдсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 29.1 тэрбум төгрөг буюу 6.7 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ. Нийт арилжааг бүтцээр нь ангилан үзвэл ноолуур 409.7 тэрбум төгрөг, хонины ноос 26.2 тэрбум төгрөг, тэмээний ноос 3.9 тэрбум төгрөг, ямааны завод ноос 0.003 тэрбум төгрөг, бодын хөөврийг 0.07 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалсан байна.

Хүснэгт 12. ХААБ-ийн арилжааны үнийн дүн, хэмжээ

№	Барааны нэр	Барааны хэмжээ /тонн/	Арилжааны дүн /тэрбум төгрөг/
1	Ноолуур	7,216	409.7
2	Хонины ноос	16,150	26.2
3	Тэмээний ноос	774	3.9
4	Ямааны завод ноос	1,639	23.2
5	Завод ноос	1.1	0.003
6	Бодын хөөвөр	4.1	0.07
	Нийт	25,784.2	463.0

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

1.6 Үнэт цаасны зах зээлийн эрэлт талын хүчин зүйлс


“Монголын хөрөнгийн бирж” ХК-д хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр нийт 886,590 данс, 139,228 холболтын данс нээгдсэн.

Нийт дансыг бүтцээр нь үзвэл, 881,962 дотоодын иргэн, 1,920 гадаадын иргэн, 2,530 дотоодын аж ахуйн нэгж, 178 гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус байна. Тайлант хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид нийт 81,017 данс шинээр нээгдсэнээс 80,899 нь дотоодын иргэн, 66 нь гадаадын иргэн, 50 нь дотоодын аж ахуйн нэгж, 2 гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд шинээр нээгдсэн дансны тоо 81 мянга болтол огцом өсөлтийг үзүүлсэн нь Засгийн газраас “Сайн хувьцаа” хөтөлбөр хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг худалдах захиалга өгөн, шинээр данс нээх болсон нь гол нөлөөг үзүүлсэн.

Арилжааны бус хэлцэл болох өв залгамжлалын нийт 248 гүйлгээ хийгдэж, давхардсан тоогоор 123 ХК-ийн 254,343 ширхэг хувьцаа, бэлэглэлээр 19 гүйлгээ хийгдэж, давхардсан тоогоор 21 ХК-ийн 145,353 ширхэг хувьцааны өмчлөх эрхийг тус тус шилжүүлсэн байна.


Дүрслэл 7. ҮЦТХТ-д нээгдсэн дансны тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн арилжааны үнийн дүнд гадаадын аж ахуйн нэгж болон иргэдийн эзлэх хувь 2.39 хувьтай байгаа бол дотоодын аж ахуйн нэгж болон дотоодын иргэдийн эзлэх хувь 97.61 хувьтай байна.

Дүрслэл 8. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь



Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

1.6.1 Үнэт цаасны арилжааны мөнгөн гүйлгээ

Засгийн газрын үнэт цаасны үндсэн ба хүүгийн төлбөрийг 2016 оны 09 дүгээр сарын 19-ны өдрөөс “ҮЦТХТ” ХХК-иас шилжүүлэн авч гүйцэтгэж байна. Монголбанкаар арилжаалагдсан Засгийн газрын үнэт цаасны 574,345,612,328.75 төгрөгийн үндсэн ба хүүгийн төлбөр, Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдсан Засгийн газрын үнэт цаасны 55,933,615,789.03 төгрөгийн үндсэн ба хүүгийн төлбөр, нийт 630,279,228,117.78 төгрөгийн төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн.

1.6.2 Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үзүүлэлтүүд

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид 316 ХК-ийн 1.4 их наяд төгрөгийн зах зээлийн үнэлгээ бүхий 22.1 тэрбум ширхэг үнэт цаас хадгалагдаж байгаагаас гадна 22 төрлийн 22.1 сая ширхэг компанийн бонд, 136 төрлийн 6.5 сая ширхэг Засгийн газрын бонд тус тус бүртгэлтэй

байна. Үүнээс 18 төрлийн 21.8 сая ширхэг компанийн бонд, 83 төрлийн 3.72 сая ширхэг Засгийн газрын бонд биржийн бус зах зээл буюу хаалттай хэлбэрээр бүртгэгдсэн байна.

Мөн “Хөдөө аж ахуйн давхар даатгал” хаалттай ХК-ийн 150.0 сая ширхэг хувьцаа, “Ард санхүүгийн нэгдэл” хаалттай ХК-ийн 22.7 сая ширхэг хувьцаа, "Апи ресурс" хаалттай ХК-ийн 2.2 сая ширхэг хувьцаа төвлөрсөн хадгаламжид тус тус бүртгэлтэй байна. Нийт Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэлтэй 313 ХК /хаалттай 3 ХК-ийг хасч тооцов/-ийн 22,011,980,050 ширхэг үнэт цаасны 70.87 хувийг төрийн өмчийн оролцоотой компанийн, 0.13 хувийг орон нутгийн оролцоотой компанийн, 29.0 хувийг төрийн мэдлийн бус буюу хувийн компанийн хувьцаа тус тус бүрдүүлж байна.

Хөрөнгө оруулагчдын хувьд ХК-ийн 5-аас дээш хувийг эзэмшигч нийт 1,389 хувьцаа эзэмшигчийн эзэмшилд 6.7 тэрбум ширхэг хувьцаа төвлөрсөн байна. Энэ нь нийт бүртгэлтэй хувьцааны 30.56 хувийг эзэлж байна.

--oOo--